



ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

Монголбанк, Хятадын ардын банкны мэргэжилтнүүдийн сүүлийн 2 жилийн хугацаанд хийсэн хэлэлцээр, хамтарсан хөдөлмөрийн үр дүнд бид өнөөдөр үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн гэрээнд гарын үсэг зурлаа. Энэхүү гэрээ нь хоёр улсын төв банк хоорондын хамтын ажиллагаанд чухал алхам болоод зогсохгүй хоёр улсын банк, санхүү, эдийн засгийн харилцааны цаашдын хөгжлийг түргэтгэх, дэмжихэд гол хөшүүрэг болох юм.

БНХАУ нь Монгол Улсын гадаад худалдааны гол түнш орон бөгөөд БНХАУ-ын юань Монгол Улсын валютын зах зээлд идэвхитэй арилжаалагддаг хоёрдахь гадаад валют юм. Иймд Монголбанк, Хятадын ардын банк хооронд дээрх своп хэлцлийн гэрээ байгуулагдсанаар Монгол Улсын гадаад худалдааны гол түнш орон болох БНХАУ-ын юанийг Монголбанк түргэн шуурхай бүрдүүлж, арилжааны банкуудын юаниар төлбөр түргэн гүйцэтгэх чадварт хүндрэл гарч валютын дотоодын захад тогтворгүй байдал үүссэн тохиолдолд захад юанийг шуурхай нийлүүлэх замаар үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх боломжтой болохоороо чухал ач холбогдолтой.

Энэхүү своп хэлцлийн гэрээ нь хамтын ажиллагааны нэг чухал хэсэг бөгөөд цаашид хоёр улсын банк санхүү, эдийн засгийн харилцааг өргөтгөх чиглэлээр Монголбанк, Хятадын ардын банк хооронд нягт хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

ФОТО СУРВАЛЖЛАГА







Монголбанкны Ерөнхийлөгч Л.Пүрэвдорж



Хятадын Ардын Банкны Ерөнхийлөгч Жоу Шиао Чуан



МОНГОЛБАНК